



RioTinto

Тогтвортой худалдан авалтын зарчим

2026 оны гуравдугаар сар



Рио Тинтогийн тогтвортой худалдан авалтын зарчим

Рио Тинтод бид ханган нийлүүлэгчид болон үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн ард иргэдтэй хамтын ажиллагаагаа хөгжүүлж, тогтвортой үнэ цэнийг бүтээх илүү үр дүнтэй арга замыг олохыг зорьдог билээ. Бид өөрсдийн авч буй бүх бараа, үйлчилгээний худалдан авалтын үйл ажиллагааг БОНЗ-ын төгс гүйцэтгэл, хариуцлагатай бизнесийн арга барилд нийцүүлэхийг эрмэлздэг.

Бид оролцогч талуудтайгаа хамтран хэрэгжүүлж буй худалдан авалтын бүхий л үйл ажиллагаандаа ил тод байдлыг эрхэмлэдгээ нотлон харуулахаар энэхүү баримт бичгийг боловсруулсан болно. Энэхүү баримт бичигт манай байгууллагын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг зарчмууд тусгагдсан. Түүнчлэн *Бидний ажлын арга барил* буюу Рио Тинтогийн Бизнесийн ёс зүйн дүрэм болон **Группийн худалдан авалтын стандарт** зэрэг дотоод баримт бичгүүдийн хамт энэхүү зарчим нь **бидний үйл ажиллагаанд тавигддаг шаардлагуудыг** тодорхойлдог.



Бидний зорилго, стратеги зорилтууд

Рио Тинто нь Хүн төрөлхтний хөгжилд нэн чухал түүхий эдийг нийлүүлэхээр ээлтэй, дэвшилтэт замаар ажиллах зорилготой бөгөөд манай ажилтнууд энэ зорилгыг хэрэгжүүлэх гол цөм нь билээ.

Бид худалдан авалтын үйл ажиллагааныхаа хүрээнд **ханган нийлүүлэгчидтэйгээ үр дүнтэй хамтран ажиллаж, тогтвортой үнэ цэнийг бий болгохыг зорьдог** бөгөөд ингэхдээ дараах аргаар стратегийн зорилтуудаа хүрэхээр ажилладаг:

- 1. Хүмүүс болон аюулгүй ажиллагааг эн тэргүүнд тавих** – амь нас эрсдэх ослыг тэглэх, ажилтнуудынхаа аюулгүй ажиллагааг хангах, үнэ цэнд суурилсан гүйцэтгэлийн соёлыг төлөвшүүлэх.
- 2. Үйл ажиллагааны төгөлдөршилд тэмүүлэх** – хөрөнгөө бүрэн хүчин чадалд нь хүргэн ашиглах, хялбаршуулах, хариуцлагыг тодорхой болгох, санхүүгийн сахилга баттай байх.
- 3. Өсөлт хөгжлийг хангах** – хөрөнгө хуваарилалтыг оновчтой болгож, өсөлтийн боломжуудыг урт хугацааны үнэ цэнд хувиргах.
- 4. Тогтвортой байдал болон нийгмийн лиценз** – нүүрстөрөгчийг бууруулах, хамгийн үнэ цэнтэй түнш байх, бизнесийн зарчмаа баримтлах замаар эрсдэлийг бууруулан, компанийн нэр хүндээ урт хугацаанд хамгаалах, орон нутаг, түншүүд болон үйлчлүүлэгчдийн итгэлийг хүлээх.

Бидний худалдан авалтын арга барил

Бид өөрсдийн ханган нийлүүлэгчдээс олон төрлийн бараа, үйлчилгээг худалдан авч, эрсдэл, үнэ цэн, үнэ төлбөрт тохирсон арга барилаар ажилладаг.

Бид хамгийн сайн тогтвортой үнэ цэнийг бүтээх зорилгоор олон тооны ханган нийлүүлэгчдээс үнийн санал, тендерийн санал авах аргыг түлхүү ашигладаг. Боломжит ханган нийлүүлэгчидтэй хэлэлцээ хийж, гэрээний хүрээнд хүлээх үүрэг хариуцлагынхаа үргэлжлэх хугацаа, бүтэц зэргийг тухайн тохиолдол бүрд нь нийцүүлэн тохируулдаг.

Бид гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу ханган нийлүүлэгчдэдээ төлбөрийг цаг тухайд нь төлж барагдуулдаг.

Бид тухайн ажлын даалгаварт холбогдох эрсдэлийн түвшинд тохирсон гэрээний стандарт маягыг ашиглахыг илүүд үздэг.

Гэрээг батлах, байгуулах үйл явцад эрх бүхий ажилтнууд хатуу хяналт тавьж, ханган нийлүүлэгчтэй харилцах харилцаандаа дүрэм журмыг дагаж мөрдөн, хариуцлагатай хандаж байгаа эсэхийг шалган баталгаажуулдаг.

Тогтвортой үнэ цэн

Бид **тогтвортой үнэ цэнийг бүтээхэд чиглэсэн худалдан авалтын** боломжуудаа үнэлэхдээ өмчлөлийн нийт зардал, чанар, гүйцэтгэл зэрэг уламжлалт хэмжүүрээс цаадхыг олж харахыг эрмэлздэг. Бид эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, ёс зүйтэй шийдвэр гаргалт, бусдыг хүндэтгэх, байгаль орчны үүрэг хариуцлага зэрэг чиглэлээр гарах бодит үр дүнг улам сайжруулахад ханган нийлүүлэгчидтэйгээ идэвхтэй хамтран ажилладаг.

Оролцогч талуудынхаа богино, дунд, урт хугацааны хэрэгцээ, ашиг сонирхлыг хангах бидний зорилтыг илтгэн харуулахуйц санхүүгийн болон санхүүгийн бус хүчин зүйлсийг бид үнэ цэн гэж тодорхойлдог. Үүний салшгүй нэг хэсэг нь манай худалдан авалтын ажиллагаа байдаг бөгөөд энэ хүрээнд бид ёс зүйтэй шийдвэр гаргахад анхаарч, хариуцлагатай арга барилаар ажиллан, хүмүүс, олон нийт, байгаль орчиндоо эерэг өөрчлөлт авчрахыг эрмэлздэг.

Ханган нийлүүлэгчидтэй тогтоосон түншлэл

Бид худалдан авалтын ажиллагаагаараа дамжуулан манай бизнест тулгараад буй асуудлуудад шийдэл олохын тулд ханган нийлүүлэлтийн зах зээлд хамтран ажилладаг. Бид бизнесийн эрэлт хэрэгцээгээ хангахаас гадна нарийн төвөгтэй сорилтуудыг шийдвэрлэх шинэлэг шийдэл боловсруулах зорилгоор ханган нийлүүлэгчидтэй харилцан ашигтай, **урт хугацааны түншлэлийн харилцаа** тогтоохыг эрхэмлэдэг.

Бидэнтэй ижил үнэт зүйлсийн төлөө ажилладаг ханган нийлүүлэгчдийг бид сонгодог. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудад үндэслэн боловсруулсан *Ханган нийлүүлэгчийн ёс зүйн дүрэм (ХНЁЗД)*-д манай **ханган нийлүүлэгчид**, тэдний салбар компаниуд, туслан гүйцэтгэгчдэд **бидний зүгээс тавих хүлээлт, шаардлагыг** тодорхойлсон байдаг. ХНЁЗД-ийг дагаж мөрдөөгүй тохиолдолд Рио Тинто тухайн ханган нийлүүлэгчтэй хамтран ажиллахаас татгалзах эсвэл бидний хүлээлт шаардлагад нийцээгүй бол хамтын ажиллагаагаа зогсоох сонголтыг хийж болно. Тохиромжтой гэж үзвэл ханган нийлүүлэгчдэд ХНЁЗД-ийн зарим заалтуудын хэрэгжилтийг сайжруулах боломж олгоно.

Ханган нийлүүлэгчидтэй хөгжүүлэх бидний түншлэл нь зөвхөн бизнесийн харилцаагаар хязгаарлагдахгүй – энэ нь бидэнд эерэг нөлөөллийг бий болгох зорилгоо биелүүлэхэд амин чухал юм. Ханган нийлүүлэгчидтэйгээ нягт хамтран ажилласнаар бид хамтын түршлага, нөөц боломжуудаа үр дүнтэй ашиглаж бодитой өөрчлөлт гаргаж, холбогдох бүх оролцогч талуудад тогтвортой өсөж хөгжих нөхцөл боломж бүрдүүлнэ.

Тогтвортой худалдан авалтын зарчим: Үндсэн чиглэл

Бид тогтвортой худалдан авалтын хүрээнд хүлээсэн үүрэг амлалтаа хэрэгжүүлэхдээ дараах үндсэн чиглэлүүдэд анхаардаг. Эдгээр чиглэлүүд нь манай баримталдаг зарчим, үнэт зүйлсийг тусгадаг бөгөөд бид худалдан авалтын ажиллагаандаа эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, ёс зүйтэй шийдвэр гаргалт, бусдыг хүндэтгэх, байгаль орчныг хамгаалахтай холбоотой үйл ажиллагааг эн тэргүүнд тавьдаг билээ. Эдгээр зарчмуудыг баримтлан ажиллахдаа бид аюулгүй ажлын байраар хангаж, нийт хангамжийн сүлжээндээ нийгмийн хариуцлагаа ухамсарлаж, нийгэмд эерэг хувь нэмэр оруулж, байгаль орчноо хамгаалахыг эрмэлздэг.



Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны гүйцэтгэл

Бид хүн бүр өдөр бүр гэртээ эсэн мэнд, эрүүл саруул харьдаг байхын төлөө ажилладаг.



Ёс зүйтэй шийдвэр гаргалт

Бид шийдвэр гаргахдаа санхүүгийн болон санхүүгийн бус хүчин зүйлсийг харгалзан үзэж, шударга зарчимтай ажиллаж, хууль тогтоомж, дүрэм журмын шаардлагыг хэрэгжүүлэн, цаг ямагт ёс зүйтэй арга барилаар ажилладаг.



Бусдыг хүндэтгэх

Бид нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийг дээдлэн, хангамжийн сүлжээндээ оролцоо, ялгаатай байдлыг дэмжиж, хүн бүрд хүндэтгэлтэй хандаж, хүний нэр төрийг дээдлэн ажиллахын төлөө байдаг.



Байгаль орчны үүрэг хариуцлага

Бидэнд хүлээлгэсэн үүрэг хариуцлагыг бид сайтар ойлгон ухамсарладаг бөгөөд бид өөрсдийгөө газар, ус зэрэг байгалийн нөөц баялаг, түүгээр тэжээгддэг экосистемийн урт хугацааны хамгаалагч юм гэж үздэг.



Орон нутгийн ард иргэд, уугуул иргэдийн ханган нийлүүлэлтийн бизнесийг хөгжүүлэх

Бид ажиллаж байгаа газар нутагтаа урт хугацааны, эерэг нөлөө бий болгохын тулд тухайн орон нутгийг идэвхтэй дэмжиж ажилладаг.



Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны гүйцэтгэл

Бид хүн бүр өдөр бүр гэртээ эсэн мэнд, эрүүл саруул харьдаг байхын төлөө ажилладаг.

Бид үйл ажиллагаандаа эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, сайн сайхан байдлыг эн тэргүүнд тавьдаг тул бидэнтэй ижил үүрэг амлалтыг хүлээн авч ажилладаг ханган нийлүүлэгчидтэй хамтран ажилладаг. Бид бүх осол зөрчил, гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлэх боломжтой гэдэгт итгэдэг учир бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд, нийт ажилтнуудын аюулгүй байдалд тулгарч болзошгүй эрсдэлийг олж тодорхойлох, удирдах, боломжтой бол арилгахад анхаардаг.



Ёс зүйтэй шийдвэр гаргалт

Бид өөрсдийн хийж буй үйлдэл бүрдээ ёс зүйтэй хандаж, аливаа шийдвэрийнхээ хүрээнд шударга байхад анхаарч, сонголт болгондоо үүрэг хариуцлагаа ухамсарлаж ажилладаг. Бид хээл хахууль, авлигын шинжтэй, эсвэл ийм байж болзошгүй бүхий л үйлдлийг хориглодог.

Бид худалдан авалтын үйл ажиллагаагаа шударга, бодитой, ил тод, мэргэжлийн түвшинд явуулдаг.

Бид ханган нийлүүлэгчидтэйгээ нээлттэй харилцаа холбоог дэмжиж, шударга, ёс зүйтэй зарчмын үндсэн дээр хамтран ажилладаг.

Хууль тогтоомж, дүрэм журмын шаардлага

Холбогдох бүх хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрддөг байх нь Рио Тинто дахь бидний худалдан авалтын арга барил юм.

Бид олон улсын стандартыг дагаж мөрдөхийг чухалчилдаг бөгөөд олон улсын хууль тогтоомжийн шаардлага нь тухайн улс орон, орон нутгийн хууль тогтоомжоос илүү хатуу байх тохиолдолд бид илүү өндөр стандартыг нь дагаж мөрдөнө. Бид хувь хүний хийж буй үйлдэл, ашиг сонирхол нь Рио Тинто, бусад сонирхогч талуудын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагатай зөрчилдөхгүй байхад анхаардаг. Бид ажил хөнгөвчлөх төлбөр гэх мэт бүхий л хэлбэрийн авлига, хээл хахуульд оролцдоггүй мөн холбогддоггүй.

Бусдыг хүндэтгэх

Бид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийг дээдлэн, оролцоог дэмжиж, орон нутгийн иргэдийг идэвхтэй дэмжиж ажиллахын төлөө байдаг.

Хүний эрх

Бид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн **хүний эрхийг хүндэтгэдэг**. Энэ хүрээнд бид хангамжийн сүлжээндээ **орчин цагийн боолчлолыг үл тэвчдэг**.

Иймээс бид ханган нийлүүлэгчийг сонгох, гэрээ байгуулахдаа хүний эрхийн хохирол (хөдөлмөрлөх эрх чөлөө, орчин цагийн боолчлолоос ангижрах болон бусад) учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хүний эрхтэй холбоотой зохих магадлан шинжилгээний ажлыг гүйцэтгэдэг.

Оролцоо, ялгаатай байдал

Манай ажилтнууд бол бидний ажлын гол цөм нь юм - бид аюулгүй ажиллагааг хангаж, итгэлцлийг бэхжүүлж, чадавхыг хөгжүүлэхэд чиглэсэн **хүндэтгэлтэй, олон талт, хүртээмжтэй орчныг** бүрдүүлдэг.

Ажилтнууддаа өөрийнхөөрөө тухтай байж чадах, оролцоог дэмжсэн хүртээмжтэй ажлын орчныг бүрдүүлж, хангамжийн сүлжээндээ олон талт, ялгаатай байдлыг дэмжих бодлогыг бид тууштай баримталдаг билээ. Ажилтан бүрийн дуу хоолойг сонсож, бүхий л соёлыг хүндэтгэн, олон янзын үзэл бодлоо илэрхийлэхийг нь сайшаагаад зогсохгүй, энэ бол бидний амжилтын салшгүй нэг хэсэг юм гэдгийг нийт ажилтнууд маань ойлгодог байхыг бид хүсдэг. Бид арьс өнгө, хүйс, гарал үүсэл, үндэс угсаа, шашин шүтлэг, нас, бэлгийн чиг хандлага болон бусдаас ялгарах шинж тэмдгээс үл хамааран бид бие биедээ тэгш, шударгаар хандаж, бусдын нэр төрийг эрхэмлэдэг.



Байгаль орчны үүрэг хариуцлага

Бидэнд хүлээлгэсэн үүрэг хариуцлагыг бид сайтар ойлгон ухамсарладаг бөгөөд бид өөрсдийгөө газар, ус зэрэг байгалийн нөөц баялаг, түүгээр тэжээн тэтгэгддэг экосистемийн урт хугацааны хамгаалагч гэж үздэг.

Бид хүрээлэн буй орчинд шаардлагагүй нөлөө учруулахааргүй бараа, үйлчилгээг худалдан авч, байгалийн баялгийг хариуцлагатайгаар ашиглахын төлөө хичээн ажилладаг. Бид ханган нийлүүлэгчидтэйгээ хамтран ажиллахдаа худалдан авч буй бараа, үйлчилгээнийхээ байгаль орчинд учруулах эрсдэлийг сайтар ойлгож, агаарт ялгарах бохирдол, усны хэрэглээ, хаягдлын удирдлага зэрэг асуудлуудыг хянадаг. Мөн ханган нийлүүлэгчидтэйгээ хамтран манай нийт хангамжийн сүлжээний хүрээнд байгаль орчинд учирч буй сөрөг нөлөөллийг зогсоох, буцаах алхмуудыг авч хэрэгжүүлдэг. Ингэхдээ бид байгаль орчны хувьд таатай ирээдүйг бүтээж, манай нийт хангамжийн сүлжээ орон нутгийн ард иргэдэд тогтвортой ашиг тусаа өгөхүйц үнэ цэнийг бий болгохыг эрмэлздэг. Мөн бид бохирдлын ялгарлыг бууруулах, дахин ашиглах боломжуудыг эрэлхийлэх, байгальд суурилсан шийдэл, ус, биологийн олон янз байдал, газар, хаягдлын удирдлагын үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгох замаар худалдан авалтын бүхий л үйл ажиллагаандаа байгаль орчинд учруулах нөлөөлөл, түүнээс хамаарах хамаарлыг багасгахын төлөө хамтран ажилладаг.

Үүнээс гадна бид хариуцлагатай хэрэглээ, хариуцлагатай үйлдвэрлэлийг хөгжүүлэн, худалдан авалтын үйл ажиллагаагаараа дамжуулан хог хаягдлыг бууруулахад анхаардаг. Манай үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг багасгаж, дахин ашиглах, дахин боловсруулах санал санаачилгуудыг дэмжин, хаягдлыг бууруулах, эргэлтийн эдийн засгийн зарчмуудыг баримтлан ажилладаг ханган нийлүүлэгчдийг бид дэмждэг.



Орон нутгийн ард иргэд, уугуул иргэдийн ханган нийлүүлэлтийн бизнесийг дэмжих

Бид ажиллаж байгаа бүхий л газар нутагтаа урт хугацааны, эерэг нөлөө үзүүлэхийн тулд шаргуу ажилладаг. Энэ хүрээнд бид **орон нутгийн ард иргэд, уугуул иргэдийн ханган нийлүүлэлтийн бизнесүүдээс бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахыг** хичээдэг.

Орон нутгийн ард иргэд, уугуул иргэдийн ханган нийлүүлэлтийн бизнесүүдтэй хамтран ажилласнаар бид тухайн орон нутгийн эдийн засгийг эрчимжүүлж, орон нутгийн ард иргэд, уугуул иргэд, тэдний бизнес цэцэглэн хөгжихөд нь тусалж чадна. Бид уугуул иргэдтэй харилцаа холбоогоо бэхжүүлж, манай үйл ажиллагаанаас бий болох боломжуудад тулгуурлан **харилцан ашигтай, хүндэтгэлтэй, ил тод хамтын ажиллагааг** хөгжүүлэх замаар уугуул иргэдийн эдийн засгийн хүсэл зорилгыг дэмжин ажилладаг.



RioTinto

Rio Tinto plc

6 St James Square
London SW1Y 4AD
United Kingdom
T+44(0)20 7781 2000

Rio Tinto Limited

120 Collins Street
Melbourne, Victoria 3000
Australia
T+61(0)3 9283 3333
riotinto.com